

БАГШ БЭЛТГЭХ СУРГУУЛЬД ЭЛСЭН СУРАЛЦАЖ БАЙГАА ОЮУТНЫ СУРАЛЦАХ ЧАДАМЖИЙН ТҮВШИНГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ДҮНГЭЭС

Д.Эрдэнэчулуун, профессор, МУБИС Э.Нарантунгалаг, МУБИС

Abstract: In this paper, the aim of the study is to determine the levels of learning skills and the output of general aptitude test given to the students who are studying in MNUE and pupils who are interested to become a teacher. The survey covered 140 pupils selected from the Pre-Teacher Education Class in the provinces such as Dundgobi, Umnugobi, Khuwsgul, and Selenge and 204 first year students from School of Social Sciences and Humanities, School of Primary Education, and from School of Mathematics and Natural Sciences at Mongolian National University of Education. Based on the survey, the students' levels of learning skills were clarified and evaluated. The findings of the study suggests that the admission criteria to MNUE should be changed.

Түлхүүр үгс: Ерөнхий авьяас буюу суралцах чадамж, оюутан, ахлах ангийн сурагчид, элсэлт, сонгон шалгаруулалт

Судалгааны үндэслэл

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагын дагуу ажиллах бүтээлч сэтгэлгээтэй, биед даан суралцах, нийгмийн өөрчлөлт шинэчлэлттэй зэрэгцэн тасралтгүй хөгжин хөрвөн ажиллах чадвартай, хариуцлагатай чадварлаг мэргэжилтэн бэлтгэх нь их дээд сургуулийн эрхэм зорилт болж байгаа билээ. Улс орны хөгжлийн тэргүүлэх салбар болох боловсролын чанарыг сайжруулах, “Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх чадамжтай багш бэлтгэх” засгийн газраас баталсан хөтөлбөрийн үзэл санааг практикт хэрэгжүүлэх нэг бодит алхам бол багш бэлтгэх сургуулиудын сонгон шалгаруулалт, элсэлтийн өнөөгийн журмыг боловсронгуй болгох замаар авьяас сонирхолтой суралцах чадамж сайтай сурагчдыг сонгон суралцуулах тогтолцоог бүрдүүлэх явдал юм. 2013 онд Багшийн сургуулийн хэсэг судлаачид, багш мэргэжил сонголтын өнөөгийн байдлийн талаар судалгаа явуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан 1-4 дамжааны оюутнуудын 52.88 % нь өөрийн сонирхлын дагуу 17.86 хувь нь элсэлтийн ерөнхий шалгалтын онооноос хамааран багшийн мэргэжлийг сонгосон байна (Оюунтунгалаг, 2013, х.114).

Боловсролын хүрээлэнгээс 2010-2011 онд хэрэгжүүлсэн “ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох” төслийн хүрээнд явуулсан судалгааны дүн, судлаачдын хийсэн дүгнэлтээс үзвэл сурагчдын 82.2 хувь нь мэргэжлийн чиг баримжаа олгох тусгайлсан сургалт хэрэгтэй, 54.5 хувь нь мэргэжлийн боловсролын сургуулиудын талаарх мэдээлэл дутмаг, 35.6 хувь сонгон гүнзгийрүүлж буй хичээлүүдийн хөтөлбөрийн агуулгад мэргэжлийн тухай тусгагдаагүй байдаг (Пүрэв, 2013, х.97). Ялангуяа багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын элсэлтийн журам, өнөөгийн шаардлага хангахгүй байгаа, илүү сайн төгсөгчдийг сонгон шалгаруулж авдаг, тэдний мэргэжлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх цогц үйл ажиллагаа дутагдаж байгаа зэргийг онцлон тэмдэглэжээ (Отгонбаяр, 2013). Эдгээр тоо баримтууд нь ЕБС-ийн ахлах ангийн олон сурагчид ажил мэргэжил болон авьяас чадамжийн талаар тодорхой ойлголт төсөөлөл баримжаагүйгээр ямар нэгэн их, дээд сургуульд элсэн суралцахыг чухалчилдаг практик хандлага боловсролын тогтолцоонд өнөө болтол давамгайлсан хэвээр байгааг харуулж байна. Энэхүү бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж, сурган хүмүүжүүлэх, сэтгэл судлалын чиглэлийн эрдэмтэн судлаачид их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан суралцагчдын суралцах авьяас чадамжийг судлахад ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй болж байгаа юм.

Авьяас сонирхол бол амжилттай суралцах, тогтвортой хөгжих сэдлийг дэмжих, хүүхэд бүрийн дотоод нөөц боломжийг нээн илрүүлэхэд чухал түлхэц үзүүлдэг сэтгэц оношилгооны нэг чухал судлагдахуун юм. Оюутан суралцагчдын ерөнхий авьяасыг судлан илрүүлж, түүнд тулгуурлан сургалтын менежментийг хийснээр дээд боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Их, дээд сургуульд суралцагчдыг сонгон элсүүлэх онол-арга зүйн шинжлэх ухааны үндэслэл бүрэн боловсрогдож, манай орны өдөр тутмын хэрэглээнд төдийлөн нэвтэрч чадаагүй байгаа явдал элсэлтийн тогтолцоог шинэчлэхэд тодорхой бэрхшээл учруулж байна. Боловсролын салбарт чанартай мэргэжилтэн бэлтгэх тогтолцоонд тулгамдаж байгаа энэхүү

асуудлыг анхааран үзэж, багш болох сонирхол, авьяастай сурагчдыг сонгон шалгаруулж, элсүүлэх аргачлалыг турших оролдлого хийж эхэлж байгаа билээ.

Орчин үед сэтгэл судлалын шинжлэх ухаанд концептуаль онолын чиг хандлагыг сонгон шалгаруулалтад нийтлэг ашиглаж байгаа бөгөөд илүү үр дүнтэй хувилбар гэж үздэг (Робертсон, 2003, х.70). Энэ онолын чиг хандлага нь тогтолцооны онолын арга судлал дээр суурилан хөгжиж байгаа бөгөөд мэргэжлийн чухал шинж чанаруудыг тодорхой хэсэг бүтцэд (блок) ангилан ялгаж, тэдгээрийг хэмжин үнэлэх замаар сонгон шалгаруулалт явуулдаг. Уг онолын үзэл баримтлалын хүрээнд дараах үзүүлэлтийг мэргэжлийн сонгон шалгаруулалт явуулахад чухалчлан үзэж байна (Маклаков, 2008, х.163). Тухайлбал,

- Ерөнхий авьяас
 - Тусгай авьяас
 - Тухайн ажил хөдөлмөрийг эрхлэх, мэргэжил эзэмших сэдэл, сонирхол гэх мэт.

Ерөнхий авьяас нь тодорхой мэргэжлээр их, дээд сургуульд амжилттай суралцах нөөц боломж, чадамжийг илэрхийлж байдаг. Харьцангуй нарийн үйлдэл гүйцэтгэх, шинэ мэдлэг эзэмших боломж буюу танин мэдэхүйн идэвхт байдлыг суралцах чадамж гэж тодорхойлжээ (Зейгарник, 1976, стр.224). Суралцах чадамж нь аливаа мэргэжил эзэмшихэд шаардагдах бие хүний чухал шинж бөгөөд ийм чадамж сайтай хүүхдүүдийн сурц, дасан зохицох чадвар илүү байдаг байна. Сурагчдыг их дээд сургуульд сонгон шалгаруулж, элсүүлэхэд ерөнхий (The General Aptitude Test Battery) авьяасыг оношлох багц сорилыг сэтгэл зүйн оношилгоонд хэрэглэж байна. Энэхүү тест нь гол төлөв оюун ухаан болон бие хүний танин мэдэхүйн онцлог шинж чанаруудыг илрүүлэх бөгөөд тухайн мэргэжлээр амжилттай суралцах, сургалтын орчинд дасан зохицох боломжийг урьчилан таамаглахад чиглэгдсэн байдгаараа онцлог юм. Оросын сэтгэл судлаач В. Н. Бузин

энэхүү тестийг Х. Амтхаурын оюун ухааны сорилыг баримжаалан зохиосон байна (Бузин В.Н. 1989, стр.112-126). Бид, ерөнхий авьяасыг оношлох дээрх сорилыг багш бэлтгэдэг их, дээд сургуульд сурагчдийг сонгон шалгаруулж элсүүлэхэд ашиглах боломжийг туршин судлахыг эрмэлзсэн болно. Ерөнхий авьяасын сорил нь нийт 50 даалгавартай бөгөөд доорх үзүүлэлтийг хэмжихэд зориулагдсан байдаг. Тухайлбал,

- Эх бичвэрт задлан шинжлэл хийх, чадамж
- Сэтгэхүйн уян хатан /гибкость/ ба хадмал хөшингө /инертность/ чанар
- Хүртэхүйн хурд, оновчит байдал
- Анхаарлын хуваарилалт, төвлөрөлт, шилжилт
- Үгийн утгыг ойлгох чадамж
- Асуудлыг шийдвэрлэх арга барил
- Орон зайн төсөөлөл гэх мэт.

Ирээдүйд багш болохыг хүсэж байгаа сурагчдын суралцах чадамж, багш хүнд байвал зохих сэтгэл зүйн шинж чанаруудыг илрүүлэхэд тохиромжтой гэж үзсэн учир тухайн арга зүйг сонгон туршилт судалгаа явуулав. Энэхүү өгүүллийн хүрээнд бид, багш бэлтгэдэг сургуульд элсэн суралцаж байгаа нэгдүгээр дамжааны оюутны суралцах чадамж буюу ерөнхий авьяасын түвшинг судалж, улмаар багш бэлтгэдэг сургуульд оюутан сурагчдыг сонгон элсүүлэх журмыг өөрчлөх талаар санал дүгнэлтээ тусгахыг зорьсон юм.

“Багш болох авьяас сонирхолтой сурагчдыг сонгон элсүүлэх ажлын шинжлэх ухааны үндсийг боловсруулах” сэдэвт төслийн хүрээнд Өмнөговь, Дундговь, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудын ахлах ангийн Багш” сонгоны хөтөлбөрт суралцаж байгаа болон багш болох сонирхолтой 140 сурагчдаас авсан судалгааны үр дүнг МУБИС-д элсэн суралцаж байгаа нэгдүгээр дамжааны 3 салбар сургуулийн 204 оюутны суралцах чадамжийн үзүүлэлттэй харьцуулан судалсан болно.

Хүснэгт 1

Судалгааны түүвэр

№	Хөдөө орон нутаг				МУБИС		
	Өмнөговь	Дундговь	Хөвсгөл	Сэлэнгэ	Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль	Математик байгалын ухааны сургууль	Багшийн сургууль
1.							
2.	32	38	32	38	85	75	44
Нийт		140				204	

Судалгааны үр дүн

Судалгааны боловсруулалтыг SPSS програм дээр хийж, үр дүнг боловсруулахдаа арифметик дундаж, стандарт дундаж хазайлт, дундаж алдаа, хамгийн их бага утга, үнэн магадлалын үзүүлэлтүүдийг тус тус тооцож гаргасан болно. Судалгааны үр дүнг хүснэгт, диаграммар харуулав.

Судалгаанд оролцсон аймгуудын ахлах ангийн сурагчид болон МУБИС-д элсэн суралцаж байгаа нэгдүгээр дамжааны оюутны ерөнхий авьяас буюу суралцах чадамжийн түвшинг гаргахад дараах үр дүн гарч байна.


Хүснэгт 2

Судалгааны үр дүн

	Нийт тоо	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга	Стандарт хазайлт
Оюутны тоо	204	4	35	20.7	5.4

Диаграмм 1


Нэгдүгээр дамжааны оюутны суралцах чадамжийн дундаж үзүүлэлт



Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын хувьд 62% нь ерөнхий авьяас буюу суралцах чадамжийн хувьд дундаж болон түүнээс дээш түвшинд байна. Тодруулж үзвэл, дундаж түвшинд үнэлэгдсэн оюутнууд ихэнх хувийг эзэлж байна. Үүний зэрэгцээ ерөнхий авьяасын үзүүлэлтийг судалгаанд оролцсон салбар сургуулиудаар харьцуулан үзэхэд дараах үр дүн гарсан болно.

Диаграмм 2

Салбар сургуулиудын оюутны суралцах чадамжийн дундаж үзүүлэлт




Судалгааны үр дүнгээс үзэхэд, математик, байгалийн ухааны сургуулийн оюутны 72 хувь нь суралцах чадамжийн хувьд дундаас дээш түвшинд байна. Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн оюутны 59 хувь нь суралцах чадамжийн хувьд дундаас дээш үзүүлэлттэй гарсан байна. Харин багшийн сургуульд элсэн суралцаж байгаа оюутны 53 хувь суралцах чадамжийн хувьд дундаас доош үзүүлэлттэй гарсан байгаа нь

төдийлөн хангалттай үзүүлэлт биш юм. Өнөөгийн элсэлтийн шалгалтад авч байгаа оноо тэдний суралцах чадамжийг илтгэх бодит үзүүлэлт болж чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулав. Ялангуяа хүүхдийн хөгжил төлөвшлийн үндэс суурийг бэхжүүлэхэд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байдаг бага ангийн багшийн ангид суралцаж байгаа суралцагчдын ерөнхий авьяас буюу суралцах чадамжийн үзүүлэлт доогуур гарч байгаа нь анхаарч үзэх шаардлагатай асуудлын нэг болж байгаа билээ. Багш бэлтгэх одоогийн тогтолцоонд илүү амжилттай, бүтээлчээр суралцах чадамжтай, зөв төлөвшилтэй төгсөгчдийг сонгон шалгаруулж авдаг цогц үйл ажиллагаа дутагдаж байгааг харуулж байна.

Үүний зэрэгцээ “Багш” сонгоны хөтөлбөрт хамрагдаж байгаа болон багш болох хүсэлтэй хөдөө орон нутгийн ахлах ангийн 140 сурагчдаас ерөнхий авьяасын судалгаа авч үр дүнг оюутны үзүүлэлттэй харьцуулж дүн шинжилгээ хийв.

Диаграмм 3

Оюутан болон ахлах ангийн сурагчдын суралцах чадамжийн үзүүлэлт



Диаграммаас харахад багш сонгонд суралцаж буй сурагчдын 78% нь ерөнхий авьяасын дундаас дээш түвшинд үнэлэгдсэн байна. Харин оюутнуудын хувьд 80% нь дунд болон түүнээс доош түвшинд үнэлэгдсэн байна. Энэ нь ерөнхий авьяас чадварын сорилын үнэлгээ багш сонгонд суралцаж буй сурагчдын хувьд илүү өндөр түвшинд байгааг харуулж байна. МУБИС-

ийн нэгдүгээр дамжаанд суралцаж буй оюутан болон багш сонгонд суралцаж байгаа сурагчдын суралцах чадамжийн дундаж үзүүлэлтүүдийн хоорондох ялгааг SPSS программыг ашиглан хосолсон t шалгуураар магадлахад ($t=-2.002$, $p=0.049$) байгаа нь үнэн магадлалын хувьд ач холбогдол бүхий түвшний ялгаатай байна.

Үүнээс үзвэл өөрсдийн авьяас сонирхлын дагуу суралцаж байгаа суралцагчдын суралцах чадамж, уралдаант шалгалтын онооны дагуу элссэн оюутны үзүүлэлтээс илүү байх магадлалтай байгааг судалгааны үр дүн харуулав. Өөрөөр хэлбэл “Багш” сонгонд суралцаж байгаа ахлах ангийн сурагчдын ерөнхий авьяас буюу суралцах чадамжийн дундаж үзүүлэлт МУБИС-д элсэн суралцаж байгаа оюутны үзүүлэлтээс өндөр гарсан болно. Судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

ДҮГНЭЛТ

1. Судалгаанд хамрагдсан нийт оюутнуудын хувьд 80% нь ерөнхий авьяас буюу суралцах чадамжийн хувьд дундаж болон түүнээс доош түвшин, харин өөрсдийн сонирхлын дагуу “Багш” сонгонд суралцаж буй сурагчдын 78 хувь нь суралцах чадамжийн үзүүлэлт дундаас дээш түвшинд үнэлэгдэж байна. Иймээс багш болох авьяас сонирхолтой хүүхдүүдийг ЕБС-иас эхлэн бэлтгэвэл илүү сайн суралцах чадамжтай сурагчдыг элсүүлж болохыг “Багш” сонгоны ангийн сурагчдын судалгааны үр дүн харуулж байна. Суралцах чадамжийн хувьд дундаас дээш үзүүлэлттэй суралцагчдыг сонгон шалгаруулж элсүүлбэл элсэлтийн чанар сайжрах нөхцөл бүрдэнэ.
2. Дээрх судалгааны үр дүн, баримтууд бол илүү амжилттай, бүтээлчээр суралцах чадамжтай төгсөгчдийг сонгон шалгаруулж авахад өнөөгийн элсэлтийн журмыг өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна. Иймээс багш боловсролын чанарыг сайжруулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих авьяас чадамжтай, тогтвортой хөгжихүйц багшийг бэлтгэхэд өнөөгийн шинжлэх ухааны мэдлэгт суурилсан элсэлтийн журмыг өөрчилж, суралцах сонирхол, авьяас чадамжийг харгалзан үнэлдэг нэгдмэл тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бужин, В.Н. (1989). Краткий ориентировочный тест // Практикум по психодиагностике. Конкретные психодиагностические методики. Москва: МГУ
- Купер, Д., Робертсон, А. (2003). Психология в отборе персонала. СПб: Питер
- Маклаков, А.Г. (2008). Профессиональный психологический отбор персонала Питер
- Отгонбаяр, Я. (2013). Багшийн мэргэжлийн социал үнэлэмж, түүнийг дээшлүүлэх асуудал “Багш боловсролын шинэчлэл. “Оюуны хөтөч” № 8. Улаанбаатар
- Оюунтунгалаг, А. (2013). Багш мэргэжлийн сонголтын өнөөгийн байдлын Судалгаа. “Оюуны хөтөч” №8. Улаанбаатар
- Пүрэв, О. (2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. Улаанбаатар
- Эрдэнэчулуун, Д. (2011). Мэргэжлээ зөв сонгох алхмууд. Улаанбаатар